

ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААН ДАХЬ ЗОХИГЧДЫГ ЭВЛЭРҮҮЛЭХ ШҮҮГЧИЙН АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ

Орчин үед иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд иргэний болон гэр бүлийн эрх зүйн маргаантай талуудыг шүүхийн журмаар эвлэрүүлэх ажиллагааг улам бүр боловсронгуй болгох нь шүүхээр зайлшгүй шийдвэрлэгдэх шаардлагагүй, эрх зүйн гэхээс илүү харилцааны маргаантай хэргийг шүүх хянан шийдвэрлэхгүй байх, шүүн таслах ажиллагааны ачааллыг багасгах боломжийг бүрдүүлж, улмаар шүүхийн зардал, ажиллагаа хэмнэгдэх ач холбогдолтойгоос гадна маргалдагч талуудыг цаг зав алдах, хөрөнгийн илүү зардал гаргах, сэтгэл зүйн хувьд хохирох зэрэг хор уршгаас урьдчилан сэргийлэх үндэс болох юм. Нөгөө талаар аливаа маргааныг хүчээр, албадлагаар шийдвэрлэх нь уг маргааныг дуусгавар болгохоос илүү далд байдалд оруулдаг төдийгүй, эцэс төгсгөлгүй үргэлжлэх муу талтай байдаг нь судалгаагаар тогтоогдсон тул талуудыг аль болох эвлэрүүлэх ажиллагаа хийх нь шүүгчийн эн тэргүүний үүрэг байх ёстой.

Монгол Улсын шүүн таслах ажиллагааны статистик мэдээнээс үзвэл 2007 онд нийт 30699 иргэний хэрэг шийдвэрлэсний 10141 буюу 33%, 2008 онд 28480 иргэний хэрэг шийдвэрлэсний 8707 буюу 30.6%, 2009 онд 35822 иргэний хэрэг шийдвэрлэсний 15322 буюу 42.8%-ийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74 дүгээр зүйлд зааснаар хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн байна. Энэхүү статистик тоон үзүүлэлтээс харахад 2009 онд өмнөх жилийн шийдвэрлэсэн хэргээс 7342-оор илүү буюу хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн хэрэг 12.2 хувь өссөн байна. Эдгээр үзүүлэлтээс үзэхэд хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн хэргийн тоо жил ирэх тутам нэмэгдэж байгаа юм. Ийнхүү хялбаршуулсан журмаар хэргийг хянан шийдвэрлэхэд шүүхийн зүгээс зохигчдод эвлэрэх боломжийг нь танилцуулснаас бус ямар нэг тодорхой ажиллагаа явуулахгүй байгааг нь учир дутагдалтай гэж үзнэ. Хэрэв шүүгч зохигчдын эвлэрэх боломжийг зөвхөн эрхийг нь тайлбарлахаар хязгаарлахгүй үр дүн, ач холбогдол, холбогдох хуулийн зохицуулалт зэргийг таниулан ойлгуулдаг бол шүүхийн хянан шийдвэрлэсэн нийт хэргийн 51-67 хувийг шүүх хуралдаан хийхгүйгээр хялбаршуулсан журмаар, зохигчдын эвлэрлээр зохицуулах боломжтой юм.

Иймээс иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад зохигчдыг эвлэрүүлэх ажиллагааны талаар нэгдсэн ойлголттой болох, холбогдох хуулийн зохицуулалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх, шүүхийн практикт гарч байгаа алдаа, зөрчлийг арилгах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд арга зүйн туслалцаа үзүүлэх зорилгоор Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3., 15.4. дэх заалтыг үндэслэн Улсын Дээд Шүүхээс ЗӨВЛӨМЖ болгох нь:

Нэг. Иргэний хэрэг, маргааны талуудыг эвлэрүүлэх ажиллагааны талаар

1.1. Аливаа маргааныг эцэслэн шийдвэрлэх үүрэг бүхий шүүгч шүүн таслах ажиллагааны төрөл бүрт маргааны оролцогчдыг эвлэрүүлэх, эв зүйгээр асуудлыг шийдвэрлэх арга ухаан, ур чадварыг эзэмшсэн байх ёстой.

1.2. Шүүгч иргэний хэрэг маргааныг шийдвэрлэх ажиллагаанд талуудыг эвлэрүүлэх талаар Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд тодорхой тусгагдаагүй боловч хуулийн хүрээнд хийх боломжтой идэвхтэй ажиллагаа явуулах тохиолдол бүрт хууль ёсны байдлыг хангаагүйгээс, мөн ёс зүйн болон харилцааны зүй бус хандлага гаргаснаас талуудад хардлага төрүүлэх, улмаар шүүхийн хөндлөнгийн байр суурийг алдагдуулах магадлалтай гэдгийг анхаарвал зохино.

1.3. Талууд бусдын албадлагагүйгээр өөрийн ухамсарт ажиллагааны үр дүнд маргааныг зохицуулах нь тэдний сэтгэл санаа, эд хөрөнгө цаг завьг барахгүйгээс гадна эрх зүйн ухамсрыг нь дээшлүүлэх үндэс суурь болохын зэрэгцээ дахин энэ төрлийн харилцаанд алдаа зөрчилгүй оролцох боломжийг бүрдүүлдэг учир шүүгч талуудад маргааны шалтгаан, нөхцөлийг тайлбарлах, алдаа, зөрчлийг нь ойлгуулах ажиллагаа явуулсны эцэст тэдгээрт өөрсдөө тохиролцох боломжийг нь олгох учиртай. Эвлэрэх болон муудалцах үйлдлийг хүн зөвхөн өөрийн хүсэл зоригор хийдэг учир шүүх эвлэрэх хүсэл зоригийг нь өдөөх л ажиллагаа явуулахаас бус ямар нэгэн хэлбэрийн дарамт үзүүлэх үндэслэлгүй гэдгийг онцгой анхаарах учиртай.

Хоёр. Гэр бүлийн холбогдолтой хэрэг маргааны талуудыг эвлэрүүлэх ажиллагааны талаар.

2.1. Сүүлийн 3 жилийн байдлаар улсын хэмжээнд шүүхээр шийдвэрлэгдсэн иргэний хэргийн 11.5-12.7 хувийг гэр бүлийн холбогдолтой хэрэг маргаан эзэлж байна.

Мөн дээрх хугацаанд гэрлэлт цуцлуулах тухай нэхэмжлэлийг хүлээн авсан шүүх гэрлэгчдэд эвлэрэх хугацаа өгөхгүйгээр шууд гэрлэлтийг цуцалсан хэргийн тоо нийт гэрлэлт цуцлуулах нэхэмжлэлтэй хэргийн 90-91 хувийг эзэлж байгаа нь шүүхийн статистик болон судалгаагаар тогтоогдсон байна. Ийнхүү шүүх гэрлэгчдийг эвлэрүүлэх талаар ямар нэг ажиллагаа хийхгүйгээр шууд гэрлэлтийг цуцалж байгаа нь шүүхийн ажлын ачаалал болон эвлэрүүлэх ажиллагааг зохицуулсан тодорхой журам Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд тусгагдаагүйтэй холбоотой байж болох талтай ч уг ажиллагааг зөвтгөх үндэслэл болохгүйг анхааруулах нь зүйтэй гэж үзлээ.

2.2. Гэр бүл нь аливаа үндэстний хөгжил, дэвшлийн эх үндэс, суурь нь болдгийн хувьд монгол гэр бүлийн бат бэх байдалд анхаарал хандуулах шаардлагын үүднээс шүүгч бүр гэрлэлт цуцлах асуудалд туйлын анхааралтай хандаж, яаруу түүхий шийдвэрээр гэр бүлийн хувь заяаг дүгнэхгүй байх нь чухал юм.

Гэрлэлтийг шууд цуцлах үндэслэлийг хуульд тодорхой заасан байдаг тул түүнд хамаарах шалтгаан нөхцөл бүрдээгүй бол гэрлэгчдийг эвлэрүүлэх тэдэнд тохирсон арга хэмжээг авбал зохино.